

ГЕРМАНЫ ЭРДЭМТЭН П.С.ПАЛЛАСЫН ХЭВЛҮҮЛСЭН
ХАЛИМАГ АРДЫН ДУУНЫ ТОЙРОНД

А.Басан

Агуулгын товч: Тус өгүүлэлд Германы эрдэмтэн П.С.Палласын 1776 онд хэвлүүлсэн Халимаг дуунуудад холбогдох сураг зангийг Палласын намтар түүх, халимаг дуунуудын, текст жич түүний агуулга, эх бичгийн ирэлт гэх хэдэн талаас анх алхам судлан шинжлэхийн зэрэгцээгээр түүнд холбогдох зарим асуудлын тухай өөрийн үзэлтээ өгүүлэв.

Түлхүүр үг: *П.С.Паллас, халимаг дуу, текст, эх бичгийн ирэлт*

Монгол ардын дуу бол аман бүтээлийн чухал нэг төрөл зүйл байж, тэр нь монголчуудын аж амьдралын хэв маяг ба оюун сэтгэлгээний түүхийг жүжиглэж тоглох хэлбэрээр эртнээс өнөө үе хүртэл уламжуулж ирсэн аман урлаг мөн. XIII зууны үед монгол газар орноор аялан тойрч байсан Европын жуулчин Плано Карпини, Вильям Рубрук, Марко Поло нарын тэмдэглэл, жич “Юань улсын судар”, “Баруун орны зурагт тэмдэглэл” зэрэг ном бүтээлд монгол дуу хөгжмийн тухай чухал сураг зангийг тэмдэглэсэн боловч монгол ардын дууг чухам аль цаг үеэс эхлэн цуглуулан тэмдэглэж, барлаж хэвлүүлсэн тухай үзэлт танилт балархай байсаар юм. Олны мэдээжээр, 1732 оны 8 сарын 9-ний өдөр Ишжавын “Монгол нутгийн урьдахаас эхэлсэн толь бичиг” хэмээх манж үсгийн судар бичигт “Цагаан овоогийн цаад биеэс”, “Самсаа дээрх даруулга чинь”, “Долоон уулын даваа” зэрэг ойрадуудын ардын дууг анх тэмдэглэсэн гар бичмэлийн уламжлалаас аваад монгол ардын дуу нь хэзээ, аль цаг үед бар хэвлэлийн уламжлалд шилжсэн тухай эрдэмтдийн үзэлт танилт ч тодорхой бус байгаа юм.

Европын Герман, Орос, Унгар, Дани, Финлянд, Польш, Чех, жич Ази тивийн Монгол, Дундад улс зэрэг улс орны эрдэмтдээс ойрад, халх, буриад, монгол ардын дууг цуглуулан тэмдэглэж, барлаж хэвлүүлсэн ном бүтээл сүүлийн үед цөөн бус олдож байгаа төдийгүй зарим нь хэвлэгдэж ирэв. Үүнд П.С.Паллас (хойшид *Паллас* (зураг 1) гэж товчилно)-ийн 1776 онд хэвлүүлсэн “Монголын угсаа ястнуудын түүхийн мэдээллийн цуглуулга” [Sammlungen historischer Nachrichten über die mongolischen Völkerschaften] гэх номын нэгдүгээр ботид 7 халимаг дуу тэмдэглэжээ (хойно *Палласын дуу* гэж товчилно).

Герман улсын эрдэмтэн Ю.Клапрот “Палласын дуу”-ны герман орчуулгад бага сага өөрчлөлт засалт хийж 1802 оны “Азийн сэтгүүл”-д нийтэлжээ (1802:547-554). Улмаар мөн Герман улсын эрдэмтэн С.Хуммел “Палласын дуу”-г 1980 онд Граз хотод гэрэл зургаар хэвлүүлсэн байна (9). Үүнээс гадна Унгар улсын эрдэмтэн Агнеш Берталанаас “Палласын дуу”-наас герман үсгээр галиглахын дагуу герман хэлээр утгачилж орчуулсан 2 халимаг дууг хэлний зүйн талаас судалгаа хийж өгүүлэл бичсэн (1987) ба мөн Халимаг улсын эрдэмтэн Церна Василий “Палласын дуу”-наас 6 дууны талаар нь товч дурдалт хийж (1988), Б.Х.Борлыков “1776 онд П.С.Паллас 6 халимаг дууг герман хэлэнд орчуулж “Монголын

угсаа ястнуудын түүхийн мэдээллийн цуглуулга” гэх номдоо хэвлүүлсэн” (2014:165) гэж товч мэдээлэл хийсэн байна. Улсын дотоодод гэвэл, Д.Таяа “1776 онд Оросын жуулчин Паллас анх монгол ардын дууг тэмдэглэсэн” (2013:133) гэх цухас дурдалт, Хасчимэгийн өгүүлсэн Палласын цуглуулж хэвлүүлсэн дууны тухай цөөн хэдэн балархай сураг занги (2013:57), жич Эрдэнэбилигийн “Герман-Оросын нэртэй эрдэмтэн, нэвтэрхий тользүйч, газар зүйч П.С.Палласын “Монгол угсаатны тухай түүхийн баримтын товчоон” хэмээх бүтээлдээ халимагийн түүхэн сэдэвт зургаан дууг герман хэлнээ орчуулан хэвлүүлсэн нь халимаг торгуудууд 1771 оны Зүүнгарын нутаг руугаа зүглэсэн түүхийг холбон бичсэн байна” (2016:373) гэх товч мэдээ ба Балжирын Дамиранжавын “Эрдэмтэн Петр Симон Паллас Хаант Оросын Шинжлэх Ухааны Академид уригдан ирж академичаар ажиллаж байхдаа XVIII зууны дунджаар Халимаг нутгаар хээрийн шинжилгээ хийж байсан байна. Тухайн үедээ тэр тэндээс хэдэн ардын дуу тэмдэглэж авсан” (2017:41-42) гэх зэрэг дөхөмхөн дурдалт төдий өгүүлэлтийг гаргавал “Палласын дуу”, жич түүнд холбогдохоор хэвлэлийн системт танилцуулга буюу тусгайлан судалж шинжилсэн өгүүлэл бүтээл улсын дотоод, гадаадад одоохон хүртэл арай харагдах үгүй байна. Доор гарын үзүүрт олдсон материал сэлтдээ суурилж “Палласын дуу”-д холбогдох сураг зангийг түүний намтар түүх, “Палласын дуу”-ны текст, жич түүний агуулга, эх бичигт холбогдох асуудал гэх хэдэн талаас анх алхам судлан шинжлэхийг зорив¹.

Нэг. Палласын намтар түүх

Петр Симон Паллас (Peter Simon Pallas) 1741 оны 9 сарын 22-ны өдөр Герман улсын Берлин хотод төрөөд 1811 онд Берлин хотод нас баржээ. Тэрбээр Оросын цагаан хаант улсын байгаль, ургамлын ухааны судлалын суурь ажлыг тавьсан алдарт эрдэмтэн болно. Тэрээр уул нь Оросын Хааны шинжлэх ухааны хүрээлэнгийн академич, биологийн ухааны профессор, Швед улсын Хааны шинжлэх ухааны хүрээлэнгийн академич, мөн англи судлалын нийгэмлэгийн гишүүн, Петербургийн аж ахуйн нийгэмлэгийн гишүүн (2001:13) зэрэг нийгмийн үүрэг тушаалыг үүрч байжээ. Палласын эцэг нь Берлин хотын анагаах ухааны газрын цэргийн мэс заслын эмч, эх нь Францын Мец (Metz - Франц улсын зүүн хойд зүгт байх эртний хот) хотоос нүүж ирсэн Христос шашны протестант шүтлэгтэн гэр бүлийн охин байжээ. Палласын эцэг, эх нь өндөр соёл боловсролтой хүмүүс байсан учраас тэрээр гэр бүлийнхээ орчин тойронд нөлөөлөгдөж грек хэл болон латин хэл сурчээ. Үүнээс гадна бас франц, англи, орос хэл мэддэг байжээ. Иймээс 1754 онд, даруй 13 настайдаа Берлин хотын анагаах ухааны мэс заслын сургуульд оюутнаар суралцахын зэрэгцээ 1758-1759 оны хооронд зэрлэг амьтны судлал, уурхайн мэргэжил, жич ургамлын ухааны мэргэжлээр суралцжээ. Улмаар Гёттинген (Göttingen) хотод шилжин ирж 1759-1760 оны хооронд ургамлын ухаан болон аж ахуйн талаар гүнзгий эзэмшиж 19 настайдаа “Хортой хорхойнууд” (2001:13) хэмээх сэдвээр доктор цол хамгаалсан байна.

1765 онд Оросын Шинжлэх Ухааны Академийн тэргүүн М.В.Ломоносов нас барсанд Оросын II Екатерина хатан хаан түүний оронд В.Орловыг сонгожээ. В.Орлов нь 1767 оны 4 сарын 22-ны өдөр Палласыг академич цол олгохоор Орост урьсанд Паллас 1767 оны 6 сарын 30-ны өдөр Петербург хотод ирж, нийгэм байгалийн ухаанд холбогдох хээрийн судалгаа хийх ажилд идэвхтэй оролцож, таван баг дугуйлан байгуулжээ (П.С.Паллас. 2001:13). Энэхүү таван баг дугуйлан дотор Паллас Оренбургийн багийг удирдан зүүншээ Байгал нуур, хойшоо Кольск нуур, жич өмнөшөө Каспийн тэнгис хүртэл аялан хээрийн шинжилгээ хийсэн байна. Энэхүү аялалын шугамыг үзүүлбэл: “Петербург (1768. 6. 21) - Великий

¹ Тус өгүүлэлд холбогдох герман хэлний материалыг орчуулахад тус дэмжлэг үзүүлсэн Чех улсын Карл хааны Их Сургууль ба Масарикийн Их Сургуулийн багш, докторонт, эрхэм номын анд Ондрей Срба болон Сианганы Эдийн засгийн Их Сургуулийн докторонт, Герман улсын уугуул, эрхэм номын анд Бэнямин Брошиг хоёрт талархсан сэтгэлээ илтгэе.

Новгород - Тверь - Клин - Москва (1768. 7. 4-14) дараа нь Владимир - Нижний Новгород - Пенза - Симбирск - Самара - Ставрополь - Волга - Симбирск хот руу буцжээ. Хаврын эхэн сард Самара хотод очиж Яайк гол (1769. 6. 28-30) - Каспийн тэнгис (1769. 8 сарын сүүлч)" (П.С.Паллас... 2001:13) хүртэл хээрийн шинжилгээ хийжээ. Паллас тус удаад Симбирск, Самара, Ставрополь, Волга, Яайк, Каспийн тэнгис зэрэг газар орноор тархан амьдарч байсан халимагчуудын дунд хээрийн шинжилгээ хийсэн байв.

Паллас ийнхүү Оросын олон муж орноор хээрийн шинжилгээ хийх үестээ ургамал, амьд бодис, газар зүй, археологи жич угсаатан зүйд холбогдох их хэмжээний эх материалыг цуглуулан тэмдэглэж, 1772 -1788 онд "Оросын Эзэн хааны газар орноор аялан жуулчилсан нь" (4 боть) (1773-1788), "Оросын Эзэн хааны газар орноор аялан жуулчилсан нь: Газрын зураг" (1788) хийгээд "Европ хийгээд Азийн хэл аялгуунуудын харьцуулсан толь" (2 боть) (1787;1789), жич "Монголын угсаа ястнуудын түүхийн мэдээллийн цуглуулга" (2 боть) (1776;1801) гэх мэтийн олон бүтээлүүдээ Оросын Эзэн хааны Шинжлэх ухааны хэвлэлийн газар хэвлүүлсэн байна. Дээр дурдсан мэт Паллас олон хэл мэдэхээр барахгүй байгаль, ургамал, амьд бодис, археологи, угсаатан зүй зэрэг мэргэжилд цагаарсан эрдэмтэн байж тэрээр Оросын эзэн хааны томилолтоор Халимаг, Буриад жич монголын Хиагтын хил орчим газар орноор тойрон байцаалт хийж монголчуудын түүх шашин, угсаатан зүй, зан үйлд холбогдох баялаг их эх хэрэглэгдэхүүнийг цуглуулж хэвлүүлсэн алдарт эрдэмтэн болно.

Палласын 1776 онд хэвлэгдсэн "Монголын угсаа ястнуудын түүхийн мэдээллийн цуглуулга" гэх номыг дундад улсын эрдэмтэн Шяо Жиан Дүн, Лү Ин Шэн хоёр хамтран герман хэлнээс хятад хэлэнд орчуулж 2002 онд "Дотоод Азийн өөлдийн түүхийн материал [内 陆亚洲厄鲁特历史资料]" гэх нэрээр Юнанийн Ардын хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн боловч "Палласын дуу"-нд холбогдох хэсгийг оруулсангүй учраас тус дуунууд нь Дундад улсын эрдэмтдийн хараанд өртөөгүй, өнөө болтол судалгааны эргэлтэнд ороогүй байсаар байна.

Хоёр. Текст, жич түүний агуулга

Палласын герман хэлээр туурвисан "Монголын угсаа ястнуудын түүхийн мэдээллийн цуглуулга" гэх номыг Санкт-Петербург дахь "Оросын эзэн хааны Шинжлэх Ухааны Академи"-ээс хоёр ботиор хэвлэжээ. Үүнд, нэгдүгээр боть нь 1776 онд (зураг 2), хоёрдугаар боть нь 1801 онд хэвлэгдсэн байна (зураг 3). Харин "Палласын дуу" нь 1776 оны нэгдүгээр ботид хэвлэгджээ. Тус номын нэгдүгээр ботийн бүтэц:

Vorrede (Оршил)

Erster Abschnitt: Von den mongolischen Stämmen überhaupt, ihrer Eintheilung und Geschichte (Нэгдүгээр бүлэг: Монголын угсаатан ястнуудын тухай ерөнхийлөн өгүүлэх нь, тэдний түүх ба монгол угсаатнуудын хуваарилал)

Zweiter Abschnitt: Von der Leibesbeschaffenheit, Kleidung, Sitten, Lebensart, Haushaltung und Krankheiten der Kalmücken und mongolischen Völkerschaften (Хоёрдугаар бүлэг: Халимаг болон бусад монголын угсаатнуудын бие махбодь, хувцас хунар, орон сууц, амьдралын хэв маяг, аж ахуй, өвчний тухай)

Dritter Abschnitt: Von der Civil- und Kriegs-Verfassung der Kalmücken und Mongolen, Gesetzen und Gericht (Гуравдугаар бүлэг: Халимаг ба монголчуудын нийгэм болон цэргийн засаг захиргаа, хууль цааз)

гэх гурван бүлгээр бүрэлджээ. "Палласын дуу"-ны текст нь тус ботийн хоёрдугаар бүлгийн 153-157 дугаар талд нийтлэгджээ (зураг 3). 153 дугаар нүүрийн дээд талд герман хэлээр "Lustbarkeiten der Kalmücken" (Халимагийн зугаа цэнгэл) хэмээн бичиж, тус нүүрийн баруун дээд талд нь герман хэлээр "Gesänge" (Дуу) гэсэн байна (зураг 4). Уул номд "Палласын дуу"-нуудаас 2 дууг герман үсгээр галиглан тэмдэглэхийн дагуу герман хэлээр утгачлан орчуулж,

бусад 5 дууг герман үсгийн галиг хадахгүйгээр шууд герман хэлээр утгачилан орчуулсан байв. Тус 7 дууны орчуулга ба агуулгын үндсэн байдлыг танилцуулбал:

(Нэг) 153 дугаар талд нийт хоёр дуу оржээ. Тус нүүрийн баруун дээр талд байх “Дуу” гэх жижиг гарчиг болон дээр талд байх “Халимагийн зугаа цэнгэл” гэх жижиг гарчгийн дараа герман хэлээр “Ein Klaggesang einer neu verehelichten jungen Frau an einen vormaligen Liebhaber, ist folgendes” (Шинэ хурималсан бүсгүйн анхны амрагтаа дуулсан гомдлын дуу) гэж тэмдэглэсэн хоёр мөр үгсийг залгаад, зүүн дээд хагас талд герман үсгийн галиг нь 21 мөр ба герман хэлний орчуулга нь 24 мөр бүхий нэг дуу оржээ. Нэгдүгээр дууны төгсгөлийн дараа герман хэлээр “Die Erfüllung ähnlicher Sehnsucht eines verliebten Mädchen wird im folgendem Liede besungen” (Таньж дасалцахгүй залууд дурласан нэгэн хүүхний мөрөөдөл биелэгдсэн тухай дараагийн дуунд дуулна) гэж тэмдэглэсэн хоёр мөр үгсийн дараа зүүн доод хагас талд 7 мөр герман үсгийн галиглал ба 7 мөр герман хэлний орчуулга бүхий нэг дууны гуравны нэг хэсэг нь орсон байна.

(Хоёр) 154 дүгээр талд, 153 дугаар талын хоёрдугаар дууны үргэлжлэлээс гадна бас нэг дуу оржээ. Даруй тус нүүрийн зүүн дээд хагас талд 153 дугаар нүүрийн хоёрдугаар дууны үргэлжлэл нь 17 мөр герман үсгийн галиглал ба 20 мөр бүхий герман хэлний орчуулгатай нэг дуу оржээ. Тус дууны төгсгөлийг залгаж, герман хэлээр “Hier ist noch ein andres verliebtes Liedchen zu welchem das Kalmückische nicht ist aufgezeichnet worden” (Халимаг үгийг нь тэмдэглэсэнгүй бас нэг хайрын дуу энэ буй) гэж тэмдэглэсэн хоёр мөр үгсийн дараа тус нүүрийн доорд хагас талд дан гагц герман хэлний орчуулгын текстийг л дагалдуулсан 14 мөр бүхий нэг дууны текст оржээ.

(Гурав) 155 дугаар нүүрэнд нийт хоёр дуу оржээ. Тус нүүрэнд герман хэлээр “Ein Klagegesang eines Mädchens über ihren im Feldzuge gebliebenen Geliebten, mit Einflechtung der Worte des Sterbenden, ist mir folgendergestalt übersezt worden” (Дайнд мордсон залуу эр хийгээд түүний амраг лугаа харилцаа дуу, дууны үгийг надад нэг хүн доорх мэт орчуулж өгөв) гэж тэмдэглэсэн хоёр мөр үгсийг залгаад герман хэлний орчуулга нь 25 мөр бүхий нэг дуу оржээ. Дээрх дууны төгсгөлийг залгаад герман хэлээр “Nachstehende Strophe soll die Sehnsucht eines von den Seinigen entfernten Kalmücken ausdrücken” (дараагийн дуу нь алс хол газар байгаа найзаа санагалзсан сэтгэлийг илтгэсэн дуу) гэх хоёр мөр үгсийн дараа герман хэлний орчуулга нь нийт 6 мөр бүхий нэг дууны хагас хэсэг нь оржээ.

(Дөрөв) 156 дугаар нүүрэнд 155 дугаар нүүрийн хоёрдугаар дууны үргэлжлэл ба бас нэг дууны хагас илүү хэсэг оржээ. Тус нүүрийн дээр талд байх “Халимагийн зугаа цэнгэл” гэх жижиг гарчиг ба зүүн дээд талын “Дуу” гэх жижиг гарчгийг гаргавал 155 дугаар нүүрийн хоёрдугаар дууны үргэлжлэлийн герман хэлний орчуулга нь 7 мөр бүхий нэг дуу оржээ. Тус дууны төгсгөлийн дараа герман хэлээр “Zuletzt will ich zwey, auf ganz neuerliche Begebenheiten gerichtete Klaglieder hersetzen, und zwar beyde auf den Abzug der Wolgischen Horde” (Эцэст нь би Ижилийн газраас нүүж явсан гэх бүр сүүлийн үед болсон хэрэг явдлын тухай хоёр гашуудлын дууг тэмдэглэе) гэх гурван мөр үгсийн дараа залгаж герман хэлний орчуулга нь 23 мөр бүхий нэг дууны хагас илүү хэсэг оржээ.

(Тав) 157 дугаар нүүрэнд 156 дугаар нүүрийн хоёрдугаар дууны үргэлжлэл ба бас нэг дуу оржээ. Тус нүүрэнд өмнөх нүүрийн хоёрдугаар дууны үргэлжлэлийн герман хэлний орчуулга нь 4 мөр бүхий нэг дуу оржээ. Тус дууны төгсгөлийн дараа герман хэлээр “Das andre” (өөр нэг дуу) гэж тэмдэглээд, дараа нь герман хэлний орчуулга нь 16 мөр бүхий нэг дуу оржээ. Тус нүүрийн хоёрдугаар дууны төгсгөлийн дараа герман хэлээр тэмдэглэсэн 13 мөр үсэг залгалдаад тус нүүр нь төгсөнө.

“Палласын дуу”-г ерөнхийд нь ажиглавал, хэдийвээр цуглуулагчаас дуунуудын гарчгийг тэмдэглэсэнгүй ч, нүүр бүрийн дууны эхэнд герман хэлээр агуулгын тойм байдлыг орчуулж танилцуулсан байна. Үүнд герман галиг ба герман хэлний орчуулга дагалдуулсан 2 дуу ба

гагц герман хэлний орчуулга дагалдуулсан 3 дуу зэрэг нийт 5 янаг хайрын дуунаас гадна, Торгуудуудын Ижил мөрний хөвөөнөөс Зүүнгар руу нүүдэлсэн түүхэнд холбогдох 2 дууг Халимаг хэлнээс шууд герман хэлэнд орчуулж тэмдэглэжээ. Ийнхүү Палласаас янаг хайр ба “Торгуудын нүүдэл”-д холбогдох нийт 7 дууг герман хэлээр орчуулж хэвлүүлсэн байна. Эдгээрээс харахад улсын дотоодод “Палласын дуу”-ны сураг зангийн тухай өнгөрсний мэдээлэлд илэрхий эндүү буруу зүйл оршиж байжээ. Жишээлбэл, Хасчимэг “Оросын нэрт байгаль судлаач, жуулчин Паллас ...1776 онд хэвлүүлсэн хоёр боть зохиол “Монгол угсаатны тухай түүхийн баримтын цуглуулга”-даа монгол ардын угсаатны зүйн судлалгаатай холбогдолтой зан үйлийн дууг орчуулан тэмдэглэх ажлыг эхлүүлсэн бөгөөд монгол ардын дууг шинжлэх ухааны үндэс баримттай судлах суурийг тавьсан байна” (2013:57) гэж өгүүлсэн байдаг. Дээр өгүүлсэнчлэн “Палласын дуу”-д янаг хайрын 5 дуу ба 2 хувь түүхэн дуу (Торгуудын их нүүдэл)-г тэмдэглэснээс биш, харин монгол ардын угсаатны зүйтэй холбогдолтой “Зан үйлийн дуу”-г тэмдэглэж хэвлүүлсэн явдал байхгүй. Тэрчлэн Паллас бол Герман улсын эрдэмтэн байж Петербургийн цагаан хааны урилгаар Оросын олон муж орноор хээрийн шинжилгээ хийсэн болохоор түүнийг “Оросын нэрт байгаль судлаач” буюу “Герман Оросын нэртэй эрдэмтэн” хэмээн ярих нь зохисгүй байна.

Гурав. “Палласын дуу”-ны эх бичгийн ирэлт, жич түүнд холбогдох асуудал

Паллас Оросын өмнөд зүгээр хээрийн шинжилгээ хийх үедээ Халимагуудын амьдарч байсан газар орноор нийт хоёр удаа аялан жуулчилжээ. Даруй 1768-1769 онд анх удаа Ижил ба Урал мөрний сав газарт очоод Халимагийн зан заншил, амьдралын хэв маягийг нүдээрээ үзэж, тэдний ном судрыг тусгай орчуулагчийн тусламжаар дамжаад Халимагуудын шашин шүтлэг зэрэгтэй танилцаж эхэлжээ (Агнеш Б. **). Хоёрдугаар удаа “1773 онд би (Паллас. Орч.) Эзэн хааны Шинжлэх Ухааны Академийн зөвшөөрлөөр Сибириэс буцах замдаа Ижил мөрний хавиар явж Царизан (одоогийн Волгоград хот. Зох.) хотод өвөлжсөн”³⁰ (1776:3) ажээ. Тэрээр тус онд Ижил мөрний баруун хөвөөгөөс эхлээд, Царизан орчим газар орноор жуулчлан Халимагуудын нүүдэл амьдрал, газар зүй, өвс ургамал, амьд бодис, түүх соёлын тухай хээрийн шинжилгээ хийжээ. Тус хоёр удаагийн хээрийн шинжилгээний явц дунд Паллас Халимагуудын дундаас 7 дуу цуглуулан өөрийн ном бүтээлдээ хэвлүүлсэн ажээ. Доор эдгээр 7 дууг тэмдэглэсэн он цагаар нь “Хоёр дууны ирэлт” ба “Бусад дуунуудын ирэлт” хэмээн хоёр хэсэгт хуваан өгүүлье.

(Нэг) Хоёр дууны ирэлт

“Палласын дуу”-аас герман галигаар тэмдэглэхийн дагуу герман хэлээр утгачилан орчуулж хэвлүүлсэн 2 дуу бол Германий Гёттингенийн Их Сургуулийн номын сангийн архив²-т хадгалагдаж байх нэгэн тод монгол үсгийн гар бичмэл эхтэй адилхан байна. Тус номын сангийн архивт хадгалагдаж байх тод монгол үсгийн гар бичмэл эх бичиг нь нийт 153 хуудастай. Уул гар бичмэлийн эхний нүүрэнд герман хэлээр “A.Sammlung von einzelnen Wörtern und Redensarten, auch einigen Aufsätzen und Briefen von Just. Fried. Malsch” [Юстүс Фридрих Малши³-ийн тэмдэглэж бичсэн үг, хэллэг өгүүлбэр, хэдэн богино бичвэр хийгээд захидлын эмхэтгэл. Хойно “Малшийн гар бичмэл текст” гэж товчилно] (зураг 5) гэж бичсэнээс үзвэл тус гар бичмэл нь Малши гэдэг хүний тэмдэглэсэн зүйл болох нь тодорхой байна. “Малшийн гар бичмэл текст”-д тус хоёр дууг тод монгол үсгээр тэмдэглэхийн дагуу үг бүрийн хажууд герман хэлний утгачилсан орчуулгыг дагалдуулжээ.

² Германий Гёттингений Их Сургуулийн номын сангийн Ашийн цуглуулгын Ash. 143-д хадгалагдаж буй.

³ Малши (1738-1778) нь угтаа мужаан, барилгачин мэргэжилтэй байжээ. Тэрээр 1766 онд тухайн үед германчууд төвлөрөн сууж байсан орны нэг болох Оросын Сарепта тосгонд ирж амьдарчээ. “Малшийн гар бичмэл текст”-д холбогдох дууны тухай тусгай өгүүлэл бичиж байгаа болохоор энд үл нуршив.

“Малшийн гар бичмэл текст” ба “Палласын дуу”-ны текстийг харьцуулахад дэмий зөрөхгүй боловч хааяа нэг зөрчилтэй асуудал оршиж байна⁴. “Малшийн гар бичмэл текст”-ийн дуунд янаг хайрт хүүхний дүрийг (ургун морь нарны гэрэлтэй минь одвол, Цэцгийн байдалтай минь)” хэмээн тод монгол үсгээр тэмдэглэж, хажуугийн герман хэлний орчуулгад “Ach dein Anblick ist mir wie das Morgenroth der Sonne, Du der meine! Deine Schönheit ist gleich den Blumen” гэж тэмдэглэсэн байхад, Палласын 1776 оны анхны боть дахь герман галигийн тэмдэглэлд “Urgun mori, Narani gar-rältäh minnih otbola, Zäzägien baidältä miniinh” гэж, хажуугийн герман хэлний орчуулгад “Ach dein Anblick ist mir wie das Morgenroth der Sonne, Du der meine! Deine Schönheit ist gleich den Blumen” гэж тэмдэглэснээс үзвэл тус хоёр хүний герман хэлний орчуулга нь адилхан байж, нэг нь нөгөөгөө мөрдөн дагаж тэмдэглэсэн шинжтэй. Үүнд “Малшийн гар бичмэл текст”-д (Ургун морь)” гэж тэмдэглэсэн үгийг Паллас мөн “Urgun mori” гэж герман галигаар адилхан тэмдэглэснээс гадна тус хоёр хүний герман хэлний орчуулгад мөн *Morgenroth* “Өглөөний нар, үүрийн туяа” хэмээн адилхан орчуулжээ. Ер нь хайрт амраг хүүхний дүрийг “Урган морь нарны гэрэлтэй” гэж дүрсэлбэл монгол хэл, соёл сэтгэхүйд арай таарахгүй үзэгдэл юм. Малши ба Паллас нар хэдийбээр “Morgenroth” (өглөөний нар, үүрийн туяа) гэж тус дууны үгийн орчин, утга санааг зөвөөр ойлгож орчуулсан боловч харин тод монгол үсэг ба герман галигаар тэмдэглэх үеэс “ургун морь” гэж эндүү буруу бичсэн байв. Гэхдээ үүнд хэн нь хэнээ хуулж тэмдэглэсэн бэ гэдэг асуудал буй. Энэ асуудалд холбогдох сонирхолтой нэгэн баримтыг дурдвал, Паллас 1776 он анхны ботид “Urgun mori” гэж тэмдэглэснээ 1801 оны хоёрдугаар ботийн залруулгын хуудсанд “Urgomar” (ургумаар) гэж сольж залруулсан байна. Паллас юунд анхны хэвлэлдээ эндүү гаргасан буй? гэвэл тэр нь “Малшийн гар бичмэл текст”-ийн нөлөө хүртсэнтэй холбоотой байж мэднэ. Учир нь Малши бол 1766 оноос 1778 он хүртэл Халимагийн Сарепта тосгонд анх ирж халимаг хэл сураад, Халимагуудын аман зохиолыг цуглуулах үеэс 2 хувь дууг тэмдэглэсэн байна. Иймээс Паллас хамаг анх тус 2 дууг цуглуулан хэвлүүлэх үеэс Малшийн “Урган морь” хэмээх эндүү тэмдэглэлийг герман галигаар “Urgun mori” хэмээн нэгэн адил буруу галиглаж хэвлүүлснээ, хожим нь хоёрдугаар ботио хэвлүүлэх үедээ, түүний дэргэд ажиллаж байсан халимаг хэлтэй орчуулагчид буюу эсхүл уншигчдын тусламжаар засаж залруулсан хэмээн таамаглаж байна. Өөрөөр хэлбэл, Палласын “Хоёр дуу” нь “Малшийн гар бичмэл текст”-тэй адилхан мөртөө түүний бурууг дагаж тэмдэглээд, дараа нь эндүүрлээ залруулснаас үзвэл тэрээр тус дууг “Малшийн гар бичмэл текст”-ээс авсан шиг байна.

(Хоёр) Бусад дуунуудын ирэлт

Палласын герман галигаар тэмдэглэхийн дагуу герман хэлээр утгачилан орчуулж хэвлүүлсэн 2 дуунаас гадна бусад 5 дууны ирэлт нь Палласын 1769 оны аялал ба 1773 оны аялалтай холбоотой байх нь гарцаагүй юм. Паллас хэдийбээр халимаг, монгол хэлэндээ Малши шиг сайн цагаарсангүй боловч 1773 оны үеэр түүний дэргэд Халимаг ярианы хэлийг сайн эзэмшсэн орчуулагч Ёхан Йериг (Johann Jählig)⁵ туслагчаар ажиллаж байжээ. Энэ тухай Паллас 1776 оны анхны ботийн оршилдоо “1773 онд би Хааны шинжлэх ухааны хүрээлэнгийн зөвшөөрлөөр Сибириэс буцах замдаа Ижил мөрний хавиар явж Царизаны хотод өвөлжив. Шинжлэх ухааны хүрээлэнгийн соёрхлоор би Царизаны хажууд байдаг Муравиан ах дүүсийн

⁴ “Палласын дуу”-ны текстийн тухай тусгай өгүүлэл бичиж байгаа тул энэхүү өгүүлэлд илүү үл нуршив.

⁵ Ёхан Йериг (Johannes Jählig) нь 1747 онд Германий Хернхүйт хотод төрөөд 1795 онд Санкт-Петербург хотод нас баржээ. Тэрээр ном хэвлэгч мэргэжилтэй байжээ. 1769 онд одоогийн Оросын Волгоград хотын нутаг дэвсгэрт байсан “Муравиан бүлэг” (“Муравиан ах дүү нарын нэгдэл” гэсэн протестант урсгалын Христосын шашны бүлгийн хүн)-ийн герман хүмүүсийн Сарепта тосгонд ирээд, тэнд индүү будах үйлдвэрт ажиллаад, үйлдвэр нь хямралд учирсны улмаас 1773 онд “Муравиан бүлэг”-ээс хаягдаж, 1774 онд Астрахань хот дахь Оросын Эзэн хааны шинжлэх ухааны Академид Палласын дэмжлэгээр оров. 1780 ба 1790 онд хоёр удаа судалгааны зорилгоор Чин улсын хязгаар нутагт айлчлав. Тэнд явахдаа төвд хэл сурчээ. Сарепта байх үедээ Халимаг хэл сураад, Халимаг хүмүүстэй явалцаж байв. Тэрээр “Төвд үсэг хийгээд хэл зүйн удиртгал”, “Монгол хэлний толь хийгээд хэл зүй” гэх хоёр зохиолыг бичсэн боловч нийтэлсэнгүй байна.

нэгдлийн Сарепта хотын иргэн Давид Ренат Ничманн⁶-ыг зураачийн хувьд болон Ёхан Йеригийг орчуулагчийн хувьд өөрийн туслагчаар хөлсөлж авсан. Нэгдүгээр нь Халимагийн зан заншил, орон сууц зэргийг зурж өгсөн, хоёрдугаар нь биеэ дааж сурсан монгол хэл, түүхийн мэдлэг болон олон төрлийн үсэг бичгийн мэдлэгээрээ надад үлэмж их тус болсон” (1776:3) гэж тэмдэглэжээ. Ийнхүү 1773 онд Палласын дэргэд халимаг ярианы хэлийг сайн эзэмшсэн орчуулагч Ёхан Йериг хийгээд зураач Дэвид Ренат Ничманн хоёр ажиллаж Палласын цуглуулсан монголчуудын соёл түүхэнд холбогдох бичиг материалыг орчуулж дэглэх ажилд их хэмжээний тусламж үзүүлж байжээ. Тус хоёр хүний уугуул нутаг нь Германий Майган гэх газар байж сүүлээр нь Сарепта⁷ тосгонд сууж байв (1776:53). Дэвид Ренат Ничманн Палласт Халимагийн зан заншил ба орон сууц зэргийг зурж өгсөн нь түүний номд орсон байдаг (зураг 6). Үүнээс үзвэл Паллас 1773 онд Халимагт хоёрдугаар удаа хээрийн шинжилгээ хийх үедээ түүний дэргэд орчуулагчаар ажиллаж байсан Ёхан Йеригийн тусламжаар 5 дууг Халимаг хэлнээс герман хэлэнд орчуулуулж авсан боломж их байна. Үүнд ялангуяа “Торгуудын их нүүдэл”-тэй холбогдох 2 гомдлын дууг тэмдэглэснээс үзвэл эдгээр дууны ирэлт нь 1771 оноос хойших учир байх ёстой. Учир нь торгуудууд 1771 оны өвөл Ижил мөрнөөс салж Зүүнгар руу нүүдэллэсэн юм. “Торгуудын их нүүдэл”-тэй холбогдох тус хоёр дуу нь “Их нүүдэл”-ийн дараа зохиогдсон болохоор Паллас эдгээр дуунуудыг тэмдэглэсэн цаг үе нь хоёрдугаар удаа 1773 онд Халимагт хээрийн шинжилгээ хийх үеийн учир болох юм.

Багцалбал:

1. Өнгөрсөнд, монгол ардын дуу нь гар бичмэлийн уламжлалын хэлбэрээр тархан дэлгэрч байсан боловч чухам аль цаг үеэс эхлэн хэвлэлийн уламжлалаар тархан дэлгэрч байсан тухай сураг занги маш ховор байсан. “Палласын дуу”-ны бар хэвлэлийн үндсэн байдлаас үзвэл, тэр нь хэдийбээр Монгол ардын дууны тусгай түүвэр биш боловч 1776 онд Оросын Эзэн хааны Шинжлэх Ухааны Академийн хэвлэлийн газраас ойрадын ардын дууны герман хэлний орчуулгыг анх удаа хэвлүүлж судлаачдад гар авлагын материал хангаснаараа монгол ардын дууны судлалд тун чухал ач холбогдолтой юм.

2. “Палласын дуу”-нууд дотор 5 дуу нь янаг хайрын тухай дуу байж, 2 дуу нь “Торгуудын их нүүдэл”-тэй холбогдох түүхэн дуу байв. Тэрчлэн Паллас эдгээр 7 дууг халимаг хэл сайн мэддэг байсан Малши хийгээд Ёхан Йериг зэрэг орчуулагчийн тусламжаар герман хэлэнд орчуулан ойрадын ардын дууг анх удаа Европын судлаачдад танилцуулсан мөртөө монгол ардын дууг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан эрдэмтэн гэж хэлж болох юм.

3. “Палласын дуу” нь хэдийбээр 250 жилийн өмнө хэвлэгдсэн боловч Дундад улсын эрдэмтдийн судалгааны эргэлтэд төдий л ороогүй, зөвхөн түүний тухай балархай сураг занги оршиж байсан болохоор түүнийг цуглуулж тэмдэглэсэн зохиогчийн намтар түүх, бар хэвлэл ба агуулга, жич эх бичгийн ирэлтийн асуудлыг тодорхойлох нь ойрадын ардын дууны судалгааны түүх бичлэг, нэн ялангуяа Монгол ардын дууны уламжлал залгамжлал хийгээд бар хэвлэлийн судлалд тун их ач холбогдолтой юм.

⁶ Дэвид Ренат Ничманн (David Renatus Nitschmann) - Паллас “Монголын угсаа ястнуудын түүхийн мэдээллийн цуглуулга” гэх номынхоо нэгдүгээр ботийн “Оршил”-д “David Renatus Nitschmann” гэж тэмдэглэсэн байхад, Агнеш Бергалан хийгээд Отто Тейхелерийн өгүүлэл ба номд “David Renatus Ritschmann” гэж зөрүү бичсэн байв. Бид Палласын тэмдэглэсэн “Nitschmann” гэх бичлэгийг баримтлав.

⁷ Сарепта - Оросын Эзэн хааны зарлигаар 1765 онд Германий Саксон мужаас Хернхүйт (“Муравиян ах дүү нарын нэгдэл”-ийн сүсэгтнийг хэлдэг, тэд Христосын шашны протестанд урсгалын нэг хэсэг болно. Ишлэгч) шашны 50 гаруй хүн халимагуудын дунд ирж амьдарсан байжээ. Сарепта тосгонд ирсэн Германчуудын гол зорилго бол Халимагуудын дунд шашин дэлгэрүүлэх, Оросын эзгүй газар нутгийг эзлэх ба аж ахуйгаа хөгжүүлэх явдал байжээ. Тус тосгон нь 1892 онд аж ахуйн талаар доройтож буурсан байв. Тус тосгоныг 1931 онд одоогийн Волгоградтай нийлүүлж Красноармейский район болгосон байна.

Номзүй

- Birtalan Ágnes.** 1987 *Zwei kalmückische Volkslieder aus dem 18. Jahrhundert.* AOH. Tom. XLI.
- Birtalan Ágnes.** 2016. *Peter Simon Pallas (1741-1811) and his Material the Beginning of Kalmuk and Oirat Studies.* Oirat Studies-2. Budapest.
- Klaproth Heinrich Julius.** *Asiatisches Magazin.* Weimar. 1802.
- P.S.Pallas.** *Sammlungen historischer Nachrichten über die mongolischen Völkerschaften.* Erster Theil. St. Petersburg. 1776. und eine Neuausgabe mit der Einleitung von S.Hummel. Graz 1980.
- Peter Simon Pallas.** *Sammlungen historischer Nachrichten über die mongolischen Völkerschaften.* 1. St. Petersburg. 1776.
- Peter Simon Pallas.** *Sammlungen historischer Nachrichten über die mongolischen Völkerschaften.* Erster Theil. St. Petersburg. 1801.
- Борлыкова Б.Х.** 2014. *К истории изучения и публикации калмыцких народных песен.* Вестник Калмыцкого института гуманитарных исследований РАН. №4.
- Дамиранжав Б.** *Ойрад халимагийн “Гэсэр”-ийг Орос болон Өрнө дахинд судар бичгээр хадгалагдаж байгаа буюу цуглуулан тэмдэглэж хэвлүүлсэн байдал.* “Хэл ба орчуулга” сэтгүүл. 2017, №2.
- Петр Симон Паллас - Ученый и путешественник.* Наука Урала. №29-30, Декабрь 2001.
- Путешествие по разным провинциям Российскаго государства Атласъ.* СПб. : При Имп. акад. наук. 1788.
- Путешествие по разным провинциям Российской Империи.* Ч. 1. СПб. : При Имп. акад. наук. 1773. *Путешествие по разным провинциям Российской Империи по повелению Санкт-Петербургской императорской академии наук.* Пер. с нем. Ф.Томанского. Ч. 1. При Имп. акад. наук. 1786. *Путешествие по разным провинциям Российской Империи по повелению Санкт-Петербургской императорской академии наук.* Пер. с нем. Ф.Томанского. Ч. 2. При Имп. акад. наук. 1786. *Путешествие по разным провинциям Российскаго государства.* Ч. 3. СПб. : При Имп. акад. наук. 1788.
- Сравнительные словари всех наречий, собранные десницею высочайшей особы. Отделение первое, содержащее в себе Азиатские и Европейские языки.* Ч. 1. СПб. Печатается в типографии у Шкора. 1787.
- Сравнительные словари всех наречий, собранные десницею высочайшей особы. Отделение первое, содержащее в себе Азиатские и Европейские языки.* Ч. 2. СПб. Печатается в типографии у Шкора. 1789.
- Таяа Д.** 2013. *Торгууд гүнж Ниржидмаагийн намтар түүхийн шинжлэл.* Д.Таяа буулгаж дэглэв. Монголын арван найман дуу шүлэг. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 2013.
- Хасчимэг.** 2013. *Монгол ардын дууны хэв загварилийн судлал.* Ляонингийн үндэстний хэвлэлийн хороо.
- Церна Василий.** *18 зун үйин халимг дуудас.* Хальмг үнэн. 1988. 1. 7.
- Эрдэнэбилэг.** 2016. *Халимаг ардын дууны цуглуулга судалгааны тойм байдал.* Гуравдугаар хугацааны монгол зан үйл соёлын олон улсын эрдэм шинжилгээний судлан ярилцах хурлын өгүүллийн эмхтгэл. Бээжин.
- 钟兴麒, 王豪, 韩慧: “西域图志校勘”, 新疆人民出版社, 2014年.
- 【德】P.S. 帕拉斯著: “内陆亚洲额鲁特历史资料”, 邵建东, 刘迎胜译, 云南人民出版社, 2002年.



Зураг 1. Палласын хөрөг зураг



Зураг 2. “Монголын угсаа ястнуудын түүхийн мэдээллийн цуглуулга” гэх номын нэгдүгээр ботийн гадар хавтас



Зураг 3. “Монголын угсаа ястнуудын түүхийн мэдээллийн цуглуулга” гэх номын хоёрдугаар ботийн гадар хавтас

Lebenszeit der Kalmücken insbesondere 175

vi, nur in jenseits Edergen und Hiesig fliegenden Edergen Seiden-
farnen.

Ein Klagefang einer neu verheirateten jungen Frau an einen
verheirateten Liebhaber, 41 folgendes:

Chaschadon Chaschadon, Ein geliebtes der schweren Kasse,
Chaschadododu jachodod du? Wie wies eine unter sich zu
liegen?

Chaschadon Jachodon Chaschadon, Du hasten alldemselben Freunde
einmal aus Liebe

Chaschadon du jachodod du? Wie wies sich darte zu hängen?
Dumbar lach schindeln den dar- War ich nicht dein angedientes
h schindeln du? Wessig apas gängen?

Dumbar lach jachodod du? War ich nicht deine verheiratete
mit schindeln du? Geliebte apas gängen?

Chaschadon Chaschadon, Deinen geliebten Brauten auch
dieser mochte zu machen, wie
schindeln du? Wie wies den?

Chaschadon Chaschadon, Wie wies einen Lieb einmal zu
hängen, wie wies?

Chaschadon Chaschadon, Wie wies einen, und lachend
du sich nicht auf die meiste
hängen?

Chaschadon Chaschadon, War ich nicht deine einzige geliebte
einst Geliebte?

Chaschadon Chaschadon, Du an jenseits Hiesig aufgeschaut
Hiesig, Kalmücken!

Chaschadon Chaschadon, War ich nicht deine einzige geliebte
einst Geliebte?

Die Erfüllung jenseits Edergen einer verheirateten Kalmücken
wie in jenseits Hiesig lachend;

Chaschadon Chaschadon, Wie wies einen, und lachend
du sich nicht auf die meiste
hängen?

Chaschadon Chaschadon, War ich nicht deine einzige geliebte
einst Geliebte?

Chaschadon Chaschadon, Du an jenseits Hiesig aufgeschaut
Hiesig, Kalmücken!

Chaschadon Chaschadon, War ich nicht deine einzige geliebte
einst Geliebte?

Ch. Kalmücken
eingelassen Kalmücken und
Kalmücken Kalmücken
auf Kalmücken Kalmücken und
Kalmücken Kalmücken
von Kalmücken Kalmücken.

BIBLIOTH.
GEORG. AUGUST.
EX DONAT.
LEBENSZEIT.

Зураг 4. “Палласын дуу”-ны текстийн герман үсгийн галиг ба герман хэлний орчуулгын эхний хуудас

Зураг 5. “Малигийн гар бичмэл текст”-ийн эхний хуудас



Зураг 6. Ничманны зурсан Халимагийн нүүдэл суудлын байдал